

ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ХАНДЛАГЫГ ҮНЭЛСЭН СУДАЛГАА

М.Бүрнээ, Ч.Өнөрцэцэг, магистр, Д.Тэмүүлэн, доктор, АШУУИС

Abstract

The incident of STD among young people aged between 15-24 years is 44% as shown in Mongolian Health Statistic of 2015. It just demonstrates that systematic health education and correct sexual behavior need to be done since very young people. The survey aimed that to evaluate the knowledge and attitude on STD prevention and to determine correlation among university students. In this study, over 1500 students are participated from Mongolian National University of Education (MNUE) and Mongolian University of Life Sciences (MULS). Average of participants age was $21,3 \pm 1,5$. Our study results showed that only 19 (38.7%) of those 49 students classified as STD prevention knowledge is sufficient, had well fixed attitudes, becoming the attitudes for 25 (51.0%), 5 (10.2%) are not attitudes approach. However, 90 (14.8%) of those 608 students who were classified as STD prevention knowledge is not sufficient had well fixed attitudes, 233 (38.3%) becoming the attitudes, 285 (46.8%) not attitudes approach.

Түлхүүр үг

Бэлгийн Замаар Дамжих Халдвар (БЗДХ), мэдлэг, хандлага, үнэлгээ

Удиртгал

ДОХ/БЗДХ нь Монгол улсад төдийгүй дэлхий дахинд нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал хэвээр байгаа өнөө үед эдгээр өвчинтэй хамтран тэмцэх санаачилгыг НҮБ-аас гаргаж, хандивлагч орнуудын буцалтгүй тусламжаар “Глобал сан”-г байгуулан, 140 оронд санхүүгийн дэмжлэг үзүүлсний нэг нь Монгол улс юм. Энэ сангийн дэмжлэгээр 2003-2013 онуудад Монгол улс 4 төсөл, 27 хөтөлбөр үр бүтээлтэй хэрэгжүүлж, ДОХ-ын тархалтыг тогтоон барьж чадсан билээ (Глобал сангийн төсөл, 2013).

Монгол улсын эрүүл мэндийн статистикийн 2015 оны мэдээллээр улсын хэмжээнд зонхилон тохиолдох БЗДХ-ын 47% тэмбүү, 30% заг хүйтэн, 23% трихомониаз өвчин тус тус эзэлж байна. БЗДХ-т 15-24 насны залуучуудын 44% өртөж байгаа нь бэлгийн идэвхтэй амьдралтай нөхөн үржихүйн насныхны дундах тулгамдсан асуудлын нэг хэвээр байсаар байна.

Орчин үед хүн амд эрүүл мэндийн боловсрол олгосноор хүмүүс өөрсдийн эрүүл мэндэд анхаарч, өвчилсөн хойно нь эмчлүүлэх бус, өвчлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх зан үйлд сургахад илүү анхаарах болжээ. Иймд эрүүл мэндийн боловсролыг бага наснаас нь системтэй эзэмшүүлэн, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, эрсдэлийг хянах нь орчин үеийн нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудын нэг билээ.

Их сургуулийн оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг судлан үнэлэхэд энэхүү судалгааны ажлын зорилго оршино⁵.

Судалгааны ажлын зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно.

- Оюутнуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийг үнэлэх
- Оюутнуудын БЗДХ-ын урьдчилан сэргийлэх хандлагыг үнэлэх
- Оюутнуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагын хамаарлыг судлах

Материал, аргазүй, хэрэглэгдэхүүн

1. Судалгааны ажлын загвар. Энэхүү судалгаанд БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг үнэлэх асуумж судалгаа, тоон болон нэгэн агшны дескриптив судалгааны аргуудыг хослуулан ашигласан болно.

2. Судалгааны ажлын хамрах хүрээ. Монгол Улсын БСШУ-ы сайдын 1А/8585 тоот тушаал, МИДСК-ын 1/52 тоот албан бичгийг үндэслэн “Оюутны эрүүл мэндийг дэмжих аян”-ы хүрээнд ДЭМБ, НҮБ-ийн Хүн амын сангийн санхүүжүүлэлтээр МУБИС болон ХААИС-ийн II, III, IV дамжааны 18-38 насны 1005 эмэгтэй, 495 эрэгтэй нийт 1500 оюутан хамрагдав (Хүснэгт 1). Судалгаанд хамрагсдын дундаж нас $21,3 \pm 1,5$ байв.

Хүснэгт 1

Судалгааны түүврийн хэмжээ

Судалгаанд хамрагсдын 366 (24.4%) Улаанбаатар хотоос, 1134 (75.6 %) хөдөө орон нутгаас дээрх сургуулиудад элссэн байв.

⁵Энэхүү судалгааг хийхэд Н.Гиймаа, Г.Нандинцэцэг, А.Гүрбадам, АШУУИС, Ж.Даваалхам, М.Тунгалаг, М.Энхтуяа, Ш.Навчисхан, Б.Дайриймаа, О.Энхжаргал, ХӨСҮТ нар оролцсон болно.

Гэр бүлийн байдлын хувьд 898 (59.87%) ганц бие, 353 (23.53%) найз охин, хөвүүнтэйгээ хамт амьдардаг, 118 (7.87%) гэрлэсэн, 109 (7.27%) хамтран амьдрагчтай бөгөөд 758 (50.53%) эцэг эхтэйгээ, 435 (29.00%) оюутны байр, хамаатан

садан, түрээсийн байранд амьдардаг байна. Өрхийн сарын дундаж орлогын хувьд дээгүүр 185 (12.34%), дундаж 1070 (71.33%), доогуур 217 (14.47%) цагийн хөдөлмөр эрхэлдэг оюутан 179 (11.93%) тус тус эзэлж байв.

Суралцаж буй дамжаа	МУБИС		ХААИС		Нийт	
	n	%	n	%	n	%
II дамжаа	15	2	26	3.467	41	2.73
III дамжаа	235	31.33	470	62.67	705	47
IV дамжаа	500	66.67	254	33.87	754	50.27
Бүгд	750	100	750	100	1500	100

Судалгааны ажлын арга зүй

Их сургуулийн оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг үнэлэх судалгааны асуумжийг боловсруулахдаа Akhtar S., Luby, S.P., Rahbar, M.H. & Azam, I (2001) нарын, МУҮСХ-ны даргын 2013 оны 01/103 тоот тушаалаар батлагдсан, ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны албаны асуумжуудыг ашигласан болно.

Их сургуулийн оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг дараах байдлаар оноогоор үнэлэв (Хүснэгт 2). Үүнд:

Хүснэгт 2

БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг үнэлсэн байдал

Мэдлэг			Хандлага	
Авбал зохих нийт оноо	Хувиар, %	Мэдлэгийн түвшин	Авбал зохих нийт оноо	Хандлагын төлөвшил
33-37	90-100	Маш сайн	9-12	Төлөвшсөн
26-32	70-89	Сайн		
18-25	50-69	Дунд	7-8	Төлөвшиж буй
11-17	30-49	Муу	0-6	Төлөвшөөгүй
10-аас бага	30%-аас бага	Хангалтгүй		

Судалгааны өгөгдлийг боловсруулалтын программ ашиглан мэдээллийн бааз үүсгэх, мэдээллийг шивэх, шивэлтийн алдааг хянах зэрэг үйлдлүүдийг гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнг шинжлэхэд SPSS 17 програмыг ашиглалаа.

Оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг үнэлэхдээ тоон судалгааны үр дүнг насны бүлэг, хүйс, дамжаа, гэр бүлийн байдал зэргээр ангилан тойм статистикийн үзүүлэлтүүдийг тооцож харууллаа. Хувьсагчийн төрлөөс хамааран тоон хувьсуурт үр дүнг бодит тоо, эзлэх хувь, дундаж утга, хамгийн бага, хамгийн их, голч утга, хамаарлыг корреляцийн коэффициент бодож илэрхийлсэн бол, чанарын хувьсуурт Пирсоны хи квадрат ашиглаж үр дүнг тайлбарлан харуулсан болно.

Судалгааны үр дүн

1. Их сургуулийн оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийг үнэлсэн нь Их сургуулийн оюутнуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийг үнэлэхэд 33-37 оноотой, маш сайн мэдлэгтэй оюутан байхгүй байна.

Харин 26-32 оноотой, сайн мэдлэгтэй 49 (3.3%) оюутан, 18-25 оноотой, дунд мэдлэгтэй 332 (22,1%), 11-17 оноотой, бага мэдлэгтэй 511(34,0%), 10-аас бага оноотой буюу хангалтгүй мэдлэгтэй 608 (40,5%) оюутан байв (Хүснэгт 3).

Хүснэгт 3


Оюутнуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийг үнэлсэн нь

Нийт оноо	Мэдлэгийн түвшин	Үнэлгээ авсан оюутны тоо
33-37	Маш сайн	0
26-32	Сайн	49 (3,3)
18-25	Дунд	332 (22,1)
11-17	Муу	511 (34,0)
10-аас бага	хангалтгүй	608 (40,5)

Судалгааны дүнгээс үзэхэд оюутнуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийн дундаж оноо 12.82+6.5 буюу хамгийн өндөр 31 оноотой 3 оюутан, хамгийн бага (0) оноотой 17 оюутан байна (Зураг 1).

Зураг 1

БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийг оноогоор үнэлсэн нь



БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийг үнэлэх асуумж нь: 1.БЗДХ-ууд, 2. Халдварлах зам, 3. Халдварлагсад илрэх шинж тэмдгүүд, 4. Эмчлэхгүй тохиолдолд үүсэх хүндрэлүүд, 5. Урьдчилан сэргийлэлт гэсэн таван хэсгээс бүрдсэн бөгөөд эдгээр асуулгад хариулсан оюутнуудын мэдлэгийн түвшин харилцан адилгүй байлаа. Үүнд:

1. БЗДХ-уудыг бусад халдварт өвчнөөс хэрхэн ялгадаг эсэхийг судлан үзэхэд судалгаанд хамрагдсан оюутнуудын 1230 (82,0%) ХДХВ/ДОХ, 1026 (68,4%) тэмбүү, 889 (59,3%) заг хүйтэн, 79 (5,3%) трихомониаз, 69 (4,6%) Гепатит С, 62 (4,1%) Гепатит В, 28 (1,9%) херпес, 8 (0,5%) хламид нь БЗДХ гэж мэдэж байна (Хүснэгт 4).

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 59,3-82,0% ХДХВ/ДОХ, тэмбүү, заг хүйтэн нь БЗДХ гэдгийг мэдэж байгаа нь дээрх халдваруудын тухай мэдээлэл олон нийтэд их мэдээлэгддэг, харин трихомониаз, хламид, херпесийн тухай мэдлэг муу байгаа нь энэ талаарх мэдээлэл бага мэдээлэгддэгтэй холбоотой гэж үзлээ.

ХДХВ/ДОХ нь БЗДХ-уудын нэг юм гэдгийг мэдэж буй оюутнуудын хувьд хүйс ($p=0.000$), гэр бүлийн ($p=0.002$) байдалд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. Тэмбүү БЗДХ юм гэдгийг мэдэж буй оюутнуудын насны ($p=0.001$) хувьд, гепатит С нь БЗДХ юм гэдгийг мэдэж буй оюутнуудын гэр бүл ($p=0.002$), насны хувьд ($p=0.006$), хламид нь БЗДХ юм гэдгийг мэдэж буй оюутнуудын хүйсийн ($p=0.002$) хувьд статистик ач холбогдол бүхий ялгаа тус тус ажиглагдлаа.

Хүснэгт 4

БЗДХ, тэдгээрийн халдварлах замын тухай мэдлэгийг үнэлсэн нь

Мэдлэгийн үзүүлэлт	Бүгд n (%)	Хүйс		p утга	Нас			p утга	Гэрлэлтийн байдал		p утга
		Эр 495n (%)	Эм 1005n (%)		20 >	21	22 <		Гэрлэсэн 580 n (%)	Гэрлээгүй 898 n (%)	
1. БЗДХалдварууд											
ХДХВ/ДОХ	1230 (82.0)	375 (75.8)	855 (85.1)	0.000*	365	442	423	0.100	374 (64.4)	507 (56.4)	0.002*
Тэмбүү	1026 (68.4)	330 (66.7)	696 (69.3)	0.311	323	359	344	0.001*	417 (71.8)	599 (66.7)	0.035
Заг хүйтэн	889 (59.3)	299 (60.4)	590 (58.7)	0.529	266	314	309	0.344	489(84.3)	726 (80.8)	0.089
Трихомониаз	79 (5.3)	22 (4.4)	57 (5.7)	0.317	19	28	32	0.530	38(6.5)	38 (4.2)	0.049
Гепатит С	69 (4.6)	20 (4.0)	49 (4.9)	0.468	8	30	31	0.006	35(6.0)	25 (2.8)	0.002*
Гепатит В	62 (4.1)	18 (3.6)	44 (4.4)	0.447	12	26	24	0.258	30(5.2)	37 (4.1)	0.342
Херпес	28 (1.9)	6 (1.2)	22 (2.2)	0.189	4	14	10	0.172	12 (2.1)	16 (1.8)	0.692
Хламид	8 (0.5)	6 (1.2)	2 (0.2)	0.000*	4	2	2	0.052	3 (0.5)	5 (0.5)	0.755
2. БЗДХ-уудын халдварлах замууд											
Бэлгийн хавьтал	1250(83.3)	395 (79.8)	855 (85.1)	0.110	384	447	419	0.000*	500 (86.2)	733 (81.6)	0.021
Зүү тариур	1056 (70.4)	327 (66.1)	729 (72.5)	0.010*	331	388	337	0.000*	380 (65.5)	571 (63.5)	0.449
Цус сэлбэх	960 (64.0)	297 (60.0)	663 (66.0)	0.024	304	337	319	0.001*	428 (73.7)	615 (68.4)	0.029
Эхээс хүүхдэд	545 (36.3)	161 (32.5)	384 (38.2)	0.031	173	189	183	0.115	244 (42)	297 (33.1)	0.000*
Дотуур хувцас солих	48 (3.2)	16 (3.2)	32 (3.2)	0.960	10	16	22	0.254	18 (3.1)	29 (3.2)	0.893

Тайлбар* p<0.01статистик холбогдол бүхий ялгаатай утга

2. БЗДХ-уудын халдварлах замыг мэддэг эсэхийг судлан үзэхэд 1250 (83,3%) нь бэлгийн хавьтал, 1056 (70,4%) зүү тариур, 960 (64,0%) цус сэлбэх, 545 (36,3%) эхээс хүүхдэд, 48 (3,2%) дотуур хувцас солих үед халдварлана гэсэн байна. БЗДХ нь бэлгийн хавьтал, зүү тариур, цус сэлбэх үед халдварладаг гэж судалгаанд хамрагдагсдын 64-83,3% нь мэдэж байгаа ч, халдвартай эхээс төрөх хүүхдэд халдвар шууд дамждаг гэдгийг ирээдүйд аав, ээж болох оюутан залуусын 545 (36,3%) нь мэдэж байна (Хүснэгт 4). Үүнээс үзэхэд БЗДХ-тай аав ээжүүдээс тэдний хойч үеийг залгамжлагч үр хүүхдүүд нь төрөлхийн халдварт өвчинтэй төрөх эрсдэлтэй гэдгийг ойлгуулах шаардлагатай гэдэг нь харагдаж байгаа ч, гэрлэсэн оюутнууд гэрлээгүй оюутнууд (p=0.000)- аас арай илүү мэддэг болох нь харагдаж байна.

БЗДХ-ууд нь бэлгийн хавьтал, цус сэлбэх замаар халдварладаг гэдгийг мэддэг оюутнуудын хувьд насны статистик ач холбогдол бүхий ялгаа (p=0.000, p=0.001) ажиглагдсан. Харин зүү тариураар БЗДХ-ууд халдварладаг гэдгийг мэддэг оюутнуудын хүйс (p=0.010), насны (p=0.000) хувьд ялгаа ажиглагдлаа (Хүснэгт 4).

3. Судалгаанд хамрагдсан оюутнуудын БЗДХ-ын үед илэрдэг шинж тэмдгүүдийн талаарх мэдлэгийг судлан үзэхэд 568 (37,9%) бэлэг эрхтэн загатнах, 567 (37,8%) бэлэг эрхтэн дээр яр шарх гарах, 482 (32,1%) шодой/үтрээнээс цагаан юм гарах, 453 (30,2%) шээх үед өвдөх, 372 (24,8%) бэлэг эрхтэн хавдах, 256 (17,1%) цустай шээх, 186 (12,4%) хэвлийгээр өвдөх, 114 (7,6%) шээс хаагдах зэрэг шинж тэмдгүүдийн тухай мэддэг байна (5-р хүснэгт).

Судалгаанд хамрагдагсдын 7,6-37,9% нь БЗДХ-ын үед илрэх ямар нэгэн шинж тэмдгүүдийг мэдэж байгаа нь энэ тухай мэдлэг тэдэнд дэндүү хомс байгааг харуулж байна. Харин БЗДХ-ын гол шинж тэмдэг болох хурыцлын үед өвддөг гэдгийг 14,4% нь мэдэж байгаа нь тэдний ихэнх нь БЗДХ-т өртөөгүй байгаатай холбоотой байж болох юм.

БЗДХ-ын үед илэрдэг шодой/үтрээнээс цагаан юм гарах (p=0.003), шээх үед өвдөх (p=0.004), хурыцлын үед өвдөх (p=0.001), хэвлийгээр өвдөх (p=0.000) зэрэг шинж тэмдгүүдийг гэрлэсэн оюутнууд гэрлээгүй оюутнуудаас илүү мэддэг байна. Шээх үед өвддөг шинж тэмдгийг эрэгтэй оюутнууд (p=0.000), бэлэг эрхтэн загатнадаг

($p=0.008$), хэвлийгээр өвддөг ($p=0.000$) шинж тэмдгийг эмэгтэй оюутнууд илүү мэддэг байна. Харин шээс хаагддаг тухай эрэгтэй оюутнууд эмэгтэйчүүдээс илүү ($p=0.006$) мэддэг байна.

Хүснэгт 5

БЗДХ-аар халдварлагсад илрэх шинж тэмдэг, эмчлэхгүй тохиолдолд үүсэх хүндрэлийн талаарх мэдлэгийг үнэлсэн нь

Мэдлэгийн үзүүлэлт	Бүгд n (%)	Хүйс		p утга	Нас			p утга	Гэрлэлтийн байдал		p утга
		Эр 495 n (%)	Эм 1005 n (%)		20 >	21	22 <		Гэрлэсэн 580 n (%)	Гэрлээгүй 898 n (%)	
3.БЗДХ-ын үед илрэх шинж тэмдгүүд											
Бэлэг эрхтэн загатнах	568(37.9)	164(33.1)	404(40.2)	0.008	153	205	210	0.440	240(41.3)	319(35.5)	0.023
Бэлэг эрхтэн дээр яр шарх үүсэх	567(37.8)	174(35.2)	393(39.1)	0.138	159	296	202	0.939	238(41.0)	325(36.1)	0.061
Шодой /үтрээнээс цагаан юм гарах	482(32.1)	182(36.8)	300(29.9)	0.007	121	185	176	0.125	213(36.7)	263(29.3)	0.003*
Шээх үед өвдөх	453(30.2)	182(36.8)	271(27.0)	0.000*	121	160	172	0.312	200(34.5)	246(27.3)	0.004
Бэлэг эрхтэн хавдах	372(24.8)	122(24.6)	250(24.9)	0.923	110	137	125	0.745	154(26.5)	214(23.8)	0.238
Цустай шээх	256(17.1)	89(18.0)	167(16.6)	0.509	75	91	90	0.948	104(17.9)	148(16.5)	0.469
Хурьцлын үед өвдөх	216(14.4)	68(13.7)	148(14.7)	0.608	56	67	93	0.031	106(18.2)	107(12.0)	0.001*
Хэвлийгээр өвдөх	186(12.4)	30(6.1)	156(15.5)	0.000*	43	64	79	0.062	90(15.5)	91(10.1)	0.002*
Шээс хаагдах	114(7.6)	51(10.3)	63(6.3)	0.006	29	39	46	0.475	55(9.5)	57(6.3)	0.026
БЗДХ-тай хүнд шинж тэмдэг илрэхгүй байх боломжтой											
Тийм	390 (69.3)	359 (72.5)	680 (67.7)	0.140	109	145	135	0.958	156 (26.8)	233 (26)	0.729
Үгүй	229 (7.2)	30 (6.1)	79 (7.9)		63	81	85		82 (14.1)	140 (15.5)	
Мэдэхгүй	881 (23.4)	106 (21.4)	246 (24.5)		256	318	307		342 (58.9)	525 (58.7)	
4.БЗДХ-ыг эмчлэхгүй тохиолдолд үүсэх хүндрэлүүд											
Үргүйдэл	892 (59.5)	295 (59.6)	597 (59.4)	0.943	248	329	315	0.722	366 (63.1)	517(57.5)	0.034
Умай, умайн хүзүүний хавдар	654 (43.6)	143 (28.9)	511 (50.8)	0.000*	184	244	226	0.760	284 (48.9)	357(39.7)	0.000*
Зулбалт	402 (26.8)	97 (19.6)	305 (30.3)	0.000*	105	151	146	0.456	181 (31.2)	215(23.9)	0.002
Дутуу төрөлт	363 (24.2)	97 (19.6)	266 (26.5)	0.003*	108	130	125	0.837	173 (29.8)	184(20.4)	0.000*
Амыгүй төрөлт	312 (20.8)	90 (18.2)	222 (22.1)	0.080	92	114	106	0.860	134 (23.1)	171(19.0)	0.060
Савны гадуурх жирэмслэлт	291 (19.4)	56 (11.3)	235 (23.4)	0.000*	82	109	100	0.892	126 (21.7)	160(17.8)	0.063

Тайлбар* $p<0.01$ статистик холбогдол бүхий ялгаатай утга

БЗДХ-тай хүнд шинж тэмдэг илрэхгүй байх боломжтой, нууц үе гэж байдаг тухай мэдлэгтэй 390 (26,0%), мэдлэггүй 1110 (73,9%) оюутан байна. Энэ нь БЗДХ-ын мэдлэг муу гэдгийг баталж байгаа бөгөөд БЗДХ-г өртөгсөд халдвараа бусдад дамжуулах, шинж тэмдэг илрэхгүй болсон үед эдгэрсэн хэмээн буруу ойлголттой болох магадлал өндөр байгааг харуулж байна. Харин энэ талаарх мэдлэгтэй оюутнуудын хүйс, нас, гэр бүлийн байдалд статистик холбогдол бүхий ялгаатай утга байхгүй байна (Хүснэгт 5).

4. БЗДХ-ыг эмчлэхгүй тохиолдолд үүсэх хүндрэлүүдийн талаарх мэдлэгийг судлан үзэхэд

судалгаанд хамрагсадын 59,5% нь үргүйдэл, 43.6% нь умай, умайн хүзүүний хавдар гэдгийг мэдэж байна. Харин 19,4-26,8% дутуу төрөлт, амыгүй төрөлт, савны гадуурх жирэмслэлт, зулбалт нь БЗДХ-ын хүндрэл гэдгийг мэдэж байгаа нь (Хүснэгт 5) энэ тухай мэдлэг хангалтгүй байгааг илэрхийлж байгаа бөгөөд, тэдэнд ЕБС-д суралцаж байх үеэс нь л мэдлэг олгох шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

БЗДХ-ыг эмчлэхгүй тохиолдолд үүсдэг умай, умайн хүзүүний хавдар, зулбалт, дутуу төрөлт, савны гадуурх жирэмслэлт зэрэг хүндрэлүүдийг судалгаанд хамрагдсан

эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ ($p=0,000-0,003$), гэрлэсэн оюутнууд гэрлээгүй оюутнуудаас илүү мэддэг ($p=0,000-0,002$) байна (Хүснэгт 5).

5. БЗДХ-аас урьдчилан сэргийлэх арга замуудын тухай мэдлэгийг үнэлэхэд судалгаанд хамрагдагсдын 1001 (66,7%) нь бэлгийн харьцаанд орох бүртээ бэлгэвч хэрэглэх, 779 (51,9%) нь халдваргүй зөвхөн нэг бэлгийн хавьтагчтай байх нь БЗДХ-аас урьдчилан сэргийлэх арга юм гэж хариулсан байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6

БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийг үнэлсэн нь

Мэдлэгийн үзүүлэлт	Бүгд n (%)	хүйс		P утга	нас			P утга	Гэрлэлтийн байдал		P утга
		Эр 495 n (%)	Эм 1005 n (%)		20 >	21	22 <		Гэрлэсэн 580 n (%)	Гэрлээгүй 898 n (%)	
5.БЗДХ-аас сэргийлэх боломжууд											
Бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэх	1001 (66.7)	375(75.8)	626 (62.3)	0.000*	300	362	339	0.157	397 (23.0)	592 (65.9)	0.314
Халдваргүй зөвхөн нэг хавьтагчтай байх	779 (51.9)	245 (49.5)	534 (53.1)	0.185	214	280	285	0.456	370 (63.7)	397 (44.2)	0.000*
Зөвхөн нэг удаагийн зүү, тариур хэрэглэх	700 (45.7)	214 (43.2)	486 (48.4)	0.061	217	258	225	0.041	292 (50.3)	399 (44.4)	0.026
Бэлгийн хавьтлыг тэвчих	653 (43.5)	214 (43.2)	439 (43.7)	0.869	210	228	215	0.022	249 (42.9)	397 (44.2)	0.629
Цус сэлбүүлэхээс татгалзах	356 (23.7)				108	98	96	0.008	159 (27.4)	173 (19.2)	0.285
Биеэ үнэлэгчтэй бэлгийн хавьталд орохоос татгалзах	302 (20.1)	150 (30.3)	206 (20.5)	0.000*	100	130	126	0.978	125 (21.5)	190 (21.1)	0.006
Гаднаас нь харахад эрүүл хүн БЗДХ-ын эрсдэлтэй байж болно											
Тийм	629 (41.9)	203 (41.0)	426 (42.4)	0.576	187	228	214	0.799	245 (50.3)	380 (50.3)	0.235
Үгүй	304 (20.2)	108 (21.8)	196 (19.5)		88	105	111		129 (50.3)	170 (50.3)	
Мэдэхгүй	567 (37.8)	184 (37.2)	383 (38.1)		153	211	203		206 (50.3)	348 (50.3)	
БЗДХ-ын шинжилгээнд хамрагдсан эсэх											
Тийм	301 (20.1)	105 (21.2)	280 (27.9)	0.000*	73	135	177	0.000*	208 (35.8)	174 (19.3)	0.000*
Үгүй	894 (59.6)	363 (73.3)	676 (67.3)		340	374	325		349 (60.1)	671 (74.7)	
Мэдэхгүй	47 (3.1)	27 (5.5)	49(4.9)		15	35	26		23(3.9)	53(5.9)	

Тайлбар* $p<0.01$ статистик холбогдол бүхий ялгаатай утга

Зөвхөн нэг удаагийн зүү тариур хэрэглэх нь БЗДХ-аас урьдчилан сэргийлэх нэг арга гэдгийг 45,7% мэдэж байгаа ч сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн байгууллага оношлогоо, эмчилгээнд нэг удаагийн зүү тариур хэрэглэж байгаа нь олон халдварт өвчнүүдээс ард иргэдээ хамгаалсан нийгмийн урьдчилан сэргийлэх арга юм. Харин бэлгийн хавьтлыг тэвчих нь БЗДХ-аас урьдчилан сэргийлэх нэгэн чухал арга гэдгийг судалгаанд хамрагдагсдын 43,5% нь мэдэж байгаа нь хангалтгүй тоон үзүүлэлт тул оюутнуудад БЗДХ авсан тохиолдолд бие махбод болон сэтгэл зүйд олон хүндрэл үүсэж, нууц үедээ орсон тохиолдолд

эдгэрсэн хэмээн ташаа ойлгон, найз нөхөд болон гэр бүлдээ халдварлуулдаг гэдгийг сайн ойлгуулах шаардлагатай байна.

Бэлгийн харьцаанд орох бүртээ бэлгэвч хэрэглэх ($p=0.314$), халдваргүй зөвхөн нэг бэлгийн хавьтагчтай байх ($p=0,000$), биеэ үнэлэгчтэй бэлгийн хавьталд орохоос татгалзах ($p=0,006$) зэрэг нь БЗДХ-аас сэргийлэх аргуудын нэг юм гэдгийг гэрлэсэн оюутнууд гэрлээгүй оюутнуудаасаа илүү хүлээн зөвшөөрсөн байна. Бэлгийн харьцаанд орох бүртээ бэлгэвч хэрэглэх, биеэ үнэлэгчтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд орохоос татгалзах ($p=0,000$) зэрэг нь БЗДХ-

аас урьдчилан сэргийлэх аргуудын нэг гэдгийг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ ($p=0,000$) илүү хүлээн зөвшөөрсөн байна.

Гаднаас нь харахад эрүүл хүн БЗДХ-ын эрсдэлтэй байж болох талаар судалгаанд хамрагсдын 629 (41,9%) мэддэг байхад, 871 (58,1%) мэдэхгүй байгаа нь БЗДХ-г өртсөн, сөрөг хандлагатай хэн нэгнээс халдвар авах магадлал өндөр байгаа гэдгийг харуулж байна. Энэ талаарх мэдлэгтэй оюутнуудын нас, хүйс, гэрлэлтийн байдалд статистик ач холбогдол бүхий ялгаатай утга байхгүй байна (Хүснэгт 6).

БЗДХ-ын тухай мэдээллийн эх үүсвэрийг судалгаанд хамрагдсан оюутнуудын 911 (60,7%) интернет/ цахим хуудас, 766 (51,1%) зурагт хуудас, мэдээллийн самбар, 696 (46,3%) сонин, сэтгүүл, ном, 610 (40,7%) найз нөхөд үе тэнгийнхэн, 607 (40,5%) радио, телевиз, 283 (18,9%) эцэг, эх, төрөл саднаас авдаг бол харин 31 (2,1%) ЕБС-ийн эрүүл мэндийн хичээл, 13 (0,86%) эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэл авдаг (Зураг 2) байна. Судалгааны дүнгээс үзэхэд цаашид энэ тухай мэдээллийг интернет/ цахим хуудсаар дамжуулан олны хүртээл болгох нь үр дүнтэй гэдгийг харуулж байгаа ч, ЕБС болон эрүүл мэндийн байгууллага энэ талаарх мэдээллийг өсвөр насныханд олгох шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

График 1

Оюутнуудын БЗДХ-ын тухай мэдээлэл авдаг эх сурвалж



Хүснэгт 8

Анхны бэлгийн хавьтал

Бэлгийн хавьталд орсон оюутны тоо	Нас				Хүйс		Хэнтэй анх бэлгийн хавьталд орсон эсэх			
	11-15	16	17	18-аас дээш	Эр (n)	Эм (n)	Найз охин, залуу	Эхнэр нөхөр	Таалагддаг охид/хөвүүд	Тохиолдлын охид/хөвүүд
1069	43	94	100	832	371	698	578	378	273	268

Судалгаанд хамрагсдын бэлгийн хавьталд орсон дундаж нас $18,9 \pm 1,8$ байна. Анх 11 настайдаа 1 охин, 12 настайдаа 1 хүү, 13 настайдаа 3 хүү, 14-15 настайдаа 20 өсвөр насныхан орсон бол 17 настайдаа буюу 100 оюутан тохиолдлын бэлгийн хавьталд орсон байгаа нь тухайн оюутны хувь хүний төлөвшилтэй холбоотойгоос гадна ЕБС-ийн сурагчдад олгож буй эрүүл мэндийн боловсрол нэн ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох асуудал дутагдалтай байгааг харуулж байна.

2. Их сургуулийн оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлагыг үнэлсэн судалгааны дүн Их сургуулийн оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлагыг үнэлсэн судалгааны дүнгээс үзэхэд 354 (23,6%) оюутанд хандлага төлөвшсөн, 674 (44,9%) оюутанд хандлага төлөвшиж буй, 472 (31,5%) оюутанд хандлага төлөвшөөгүй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7


Оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлагыг үнэлсэн нь

Авбал зохих оноо	Хандлагын үнэлэмж	Үнэлгээ авсан оюутны тоо (%)
9-11	Төлөвшсөн	354 (23.6%)
7-8	Төлөвшиж буй	674 (44.9%)
0-6	Төлөвшөөгүй	472 (31.5%)

Судалгааны дүнгээс үзэхэд 0-3 оноотой 92 оюутан, 4-6 оноотой 380, 7-9 оноотой 928 оюутан, 10-11 оноотой 100 оюутан байна (Зураг 3).

График 2

Хандлагын төлөвшлийг үнэлсэн оноо



Судалгаанд оролцогсдын 1069 (71,3) бэлгийн хавьталд орсон, 431 (28,7) нь бэлгийн хавьталд ороогүй байна. Бэлгийн хавьталд орсон 1069 оюутны нас, хүйс, гэрлэлтийн байдлыг судлан үзэв (хүснэгт 8).

БЗДХ нь эдгэрэх боломжтой учраас аюултай биш юм гэж судалгаанд хамрагдсан 279 (19,8%) оюутан үзэж байгаа нь тэдэнд хандлага төлөвшөөгүйг, 630 (42%) оюутан энэ талаар мэдэхгүй байгаа нь БЗДХ-уудын ямар халдвар нь эмчлэгдэн эдгэрэх, эмчлэгдэхгүй талаарх мэдлэг хомс байгааг харуулж байна. БЗДХ нь эдгэрэх боломжтой ч сөрөг үр дагавар ихтэй гэдгийг эмэгтэй оюутнууд эрэгтэйчүүд ($p=0.013$)-ээс, гэрлэсэн оюутнуудад гэрлээгүй оюутнууд ($p=0.012$)-аас илүү мэдэж байна (Хүснэгт 9).

БЗДХ нь нэг хүнээс нөгөөд дамждаг тул түүнээс зайлсхийх хэрэгтэй гэж 1065 (71,0%), БЗДХ-тай залуучууд эмчлүүлэх шаардлагатай гэж 1330 (88,7%), БЗДХ-ын шинж тэмдэг илэрч байгаад эргэлзэж байгаа бол эмнэлэгт хандах хэрэгтэй гэж 1343 (89,5%) урьдчилан сэргийлэх зорилгоор байнга мэдээлэл авч байх ёстой гэж 1354 (90,3) үзэж байгаа нь хандлага сайн төлөвшсөнийг харуулж байна. Харин хандлагын төлөвшлийг шалгасан дээрх асуултуудад судалгаанд хамрагдсан оюутнуудын 0.7-6.5% нь зөвшөөрөхгүй хэмээн хариулснаас үзэхэд тэдэнд хандлага төлөвшөөгүй байгааг харуулж байна. 8.3-42% нь мэдэхгүй хэмээн хариулснаас үзэхэд тухайн оюутнууд БЗДХ-уудын тухай ерөнхий мэдлэггүйгээс гадна, хувь хүнд хандлага төлөвшөөгүй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 9

Оюутнуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлага

Хандлагын үзүүлэлт	Бүгд n (%)	Хүйс		p утга	Нас			p утга	Гэрлэлтийн байдал		p утга
		эр 495 n (%)	Эм 1005 n (%)		20 >	21	22 <		гэрлэсэн 580 n (%)	гэрлээгүй 898 n (%)	
Бэлгийн замын халдварт өвчин эдгэрэх боломжтой учраас аюултай биш юм											
Зөвшөөрнө	297(19.8)	100 (20.2)	197(19.6)	0.013	82	114	101	0.889	128(22.1)	165(18.3)	0.012
Зөвшөөрөхгүй	573 (38.2)	212 (42.8)	361(35.9)		165	200	208		235 (40.5)	328(36.5)	
Мэдэхгүй	630 (42.0)	183 (36.9)	447(44.4)		*	181	230		219	217 (37.4)	
БЗДХ нэг хүнээс нөгөөд дамждаг тул түүнээс зайлсхийх хэрэгтэй											
Зөвшөөрнө	1065(71.0)	350 (70.7)	715 (71.1)	0.563	306	390	369	0.218	428(73.7)	624 (69.4)	0.203
Зөвшөөрөхгүй	98 (6.5)	37 (7.4)	61 (6.0)		28	26	44		34 (5.8)	62 (6.9)	
Мэдэхгүй	337 (22.5)	108 (21.8)	229 (22.7)		94	128	115		118 (20.3)	212 (23.6)	
БЗДХ-тай залуучууд заавал эмчлүүлэх шаардлагатай											
Зөвшөөрнө	1330 (88.7)	436 (88.0)	894 (88.9)	0.266	383	488	459	0.492	521 (89.8)	791 (88.0)	0.096
Зөвшөөрөхгүй	20 (1.3)	10 (2.0)	10 (0.9)		4	6	10		11 (1.8)	9 (1.0)	
Мэдэхгүй	150 (10.0)	49 (9.8)	101 (10.0)		41	50	59		48 (8.2)	98 (10.9)	
Залуучууд өөртөө БЗДХ-ын шинж тэмдэг илэрч байгаад эргэлзэж байгаа бол эмнэлэгт хандах хэрэгтэй											
Зөвшөөрнө	1343 (89.5)	439 (88.6)	904 (89.9)	0.766	396	492	455	0.031	526(90.6)	799 (88.9)	0.545
Зөвшөөрөхгүй	11 (0.7)	4 (0.8)	7 (0.6)		1	3	7		5 (0.8)	6 (0.66)	
Мэдэхгүй	145 (9.8)	52 (10.5)	93 (9.2)		31	49	65		49 (8.4)	92 (10.2)	
Залуучууд БЗДХ-аас урьдчилан сэргийлэх зорилгоор байнга мэдээлэл авч мэдлэгтэй болох ёстой											
Зөвшөөрнө	1354 (90.3)	438 (88.4)	916 (91.1)	0.295	394	492	468	0.438	533 (91.8)	805 (89.4)	0.344
Зөвшөөрөхгүй	20 (1.3)	9 (1.8)	11 (1.1)		3	7	10		5 (0.8)	15 (1.6)	
Мэдэхгүй	125 (8.3)	48 (9.6)	77 (7.6)		31	45	49		42 (7.2)	78 (8.6)	
Хэрэв та ямар нэгэн БЗДХ авсан бол таны санаа хэр зовох вэ?											
Санаа зовохгүй	22 (1.5)	20 (4.0)	3 (0.3)	0.000*	4	7	12	0.140	3 (0.5)	20 (2.2)	0.004
Бага зэрэг санаа зовно	62 (4.1)	39 (7.8)	23 (2.3)		19	24	19		25 (4.3)	34 (3.7)	
Санаа их зовно	1250 (83.3)	369 (74.5)	881 (87.6)		370	442	438		503 (86.7)	732 (81.5)	
Мэдэхгүй	165 (11.0)	67 (13.5)	98 (9.7)		35	71	59		49 (8.4)	112 (12.4)	

Тайлбар* $p<0.01$ статистик холбогдол бүхий ялгаатай утга

Хэрвээ БЗДХ авсан бол тухайн оюутан сэтгэл санааны хувьд хэр тавгүй байдалд байх тухай судлан үзэхэд 1250 (83,3%) оюутан санаа их зовно гэсэн тул хандлага бүрэн төлөвшсөн, 62 (4.1%) оюутан санаа бага зовно гэсэн тул хандлага төлөвшиж буй, 22(1.5%) оюутан санаа зовохгүй, 165 (11%) оюутан мэдэхгүй гэж хариулсан тул хандлага төлөвшөөгүй гэж үзэж байна. БЗДХ

авсан тохиолдолд эмэгтэй оюутнууд эрэгтэйчүүд ($p=0.000$)-ээсээ, гэрлээгүй оюутнууд гэрлэсэн оюутнууд ($p=0.004$)-аас илүү санаа зовно гэсэн нь судалгааны ажлын статистикийн үр дүнгээс харагдаж байна. Дээрх судалгаанаас үзэхэд БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлага эмэгтэй, гэр бүлтэй оюутнуудад төлөвшсөн гэж дүгнэж байна (Хүснэгт 9).

БЗДХ-аас урьдчилан сэргийлэх зорилгоор бэлгэвч хэрэглэх хэрэгтэй гэж 1339 (89,3%) оюутан үзэж байгаа нь хандлага сайтай болохыг харуулж байна. Гэвч “Хэрэв хэн нэгэнтэй бэлгийн харьцаанд орох нөхцөл бүрдсэн үед танд бэлгэвч байхгүй бол та яах вэ?” гэдэг талаар судлан үзэхэд 121 (8,1%) бэлгийн харьцаанд орно, 514 (34,3%) мэдэхгүй, “Найз охин/хөвгүүнтэйгээ бэлгийн харьцаанд орох нөхцөл бүрдсэн үед хайрт чинь бэлгэвч хэрэглэх саналыг татгалзвал яах вэ?” гэсэн асуултад гомдоохгүйн тулд бэлгэвч хэрэглэхгүй 6,5%, тухайн нөхцөл байдлаас хамаарна гэж 33,3%, мэдэхгүй гэж 17% нь хариулсан байна. Судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан оюутнууд ихэнх нь БЗДХ-аас урьдчилан сэргийлэх зорилгоор бэлгэвч хэрэглэх хэрэгтэй гэсэн боловч “Бэлгийн харьцаанд орох нөхцөл бүрдсэн үед бэлгэвч байхгүй” тохиолдолд түүнийг хэрэглэдэггүй болох нь тодорхой байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10 Бэлгэвчийн хэрэглээ

Хандлагын үзүүлэлт	Бүгд n (%)	Хүйс		p утга	Нас			p утга	Гэрлэлтийн байдал		p утга
		эр 495 n (%)	эм 1005 n (%)		20 >	21	22 <		Тийм 580 n (%)	Үгүй 898 n (%)	
БЗДХ-аас урьдчилан сэргийлэхийн тулд бэлгийн хавьтлын үед бэлгэвч хэрэглэх хэрэгтэй											
Зөвшөөрнө	1339(89.3)	455 (91.9)	884 (87.9)	0.002 *	390	480	469	0.122	520 (89.6)	803 (89.4)	0.870
Зөвшөөрөхгүй	25 (1.7)	12 (2.4)	13 (1.3)		3	8	14		10 (1.7)	13 (1.4)	
Мэдэхгүй	136 (9.1)	28 (5.6)	108 (10.7)		35	56	45		50 (8.6)	82 (9.1)	
Хэрэв хэн нэгэнтэй бэлгийн харьцаанд орох нөхцөл бүрдсэн үед танд бэлгэвч байхгүй бол та яах вэ?											
Зөвшөөрнө	121 (8.1)	74 (14.9)	47 (4.6)	0.000 *	32	40	49	0.769	42 (7.2)	76 (8.4)	0.109
Зөвшөөрөхгүй	865 (57.7)	233 (47.0)	632 (62.8)		245	319	301		355 (61.2)	500 (55.6)	
Мэдэхгүй	514 (34.3)	188 (37.9)	326 (32.4)		151	185	178		183 (31.5)	322 (35.8)	
Хайртай найзтайгаа бэлгийн харьцаанд орох нөхцөл бүрдсэн үед хайрт чинь бэлгэвч хэрэглэх саналыг татгалзвал та яах вэ?											
Гомдоохгүйн тулд бэлгэвч хэрэглэхгүй	98 (6.5)	77 (15.5)	21 (2.1)	0.000 *	13	43	42	0.030	40 (6.9)	58 (6.4)	0.003*
Бэлгийн харьцаанаас татгалзана	288 (19.2)	63 (12.7)	225 (22.3)		90	102	96		87 (15.0)	198 (22.0)	
Бэлгэвч заавал хэрэглэнэ	360 (24.0)	108 (21.8)	252 (25.0)		117	119	124		153 (26.3)	202 (22.4)	
Тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарна	499 (33.3)	175 (35.3)	324 (32.2)		131	189	179		211 (36.3)	279 (31.1)	
Мэдэхгүй	255 (17.0)	72 (14.5)	183 (18.2)		77	91	87		89 (15.3)	161 (17.9)	

Тайлбар* p<0.01 статистик холбогдол бүхий ялгаатай утга

Бэлгэвчийн хэрэглээний хандлагыг үнэлсэн дээрх асуултуудад хариулсан оюутнуудын хүйс, гэр бүлийн байдалд статистик холбогдол бүхий ялгаатай утгууд хариулт тус бүрд харилцан адилгүй байлаа (Хүснэгт 10).

Судалгаанд хамрагсдын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлагын төлөвшлийг хүйсийн хувьд харьцуулан судлахад эмэгтэй (28.2%)-чүүд эрэгтэй (14.1%)-чүүдээсээ илүү төлөвшсөн байна.

Харин хандлага төлөвшөөгүй эрэгтэй оюутнууд (38.9%) эмэгтэйчүүдээсээ олон байж, хүйсийн ялгаа ажиглагдлаа (p=0.000). БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлага төлөвшсөн оюутнуудын гэр бүлийн байдлыг харьцуулан судлахад гэрлэсэн оюутан 189 (32.5%)-ууд гэрлээгүй оюутан 161 (17.9%)-уудаасаа илүү олон байна. Харин ганц бие оюутнуудын ихэнхэд нь хандлага төлөвшөөгүй болох нь харагдаж байна (p=0.000) (хүснэгт 11).

Хүснэгт 11

БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлагын төлөвшлийг үнэлсэн нь

Хандлагын бүлэг	Бүгд n (%)	Хүйс		p утга	Нас			p утга	Гэрлэлтийн байдал		p утга
		Эр 495 n (%)	Эм 1005 n (%)		20 >	21	22 <		гэрлэсэн 580 n (%)	гэрлээгүй 898 n (%)	
Төлөвшсөн	354 (23.6)	70 (14.1)	284 (28.2)	0.000*	92	128	134	0.606	189 (32.5)	161 (17.9)	0.000*
Төлөвшиж буй	674 (44.9)	232 (46.8)	442 (43.4)		197	251	226		256 (44.1)	409 (45.5)	
Төлөвшөөгүй	472 (31.4)	193 (38.9)	279 (27.7)		139	165	168		135 (13.4)	328 (36.5)	

1. Их сургуулийн оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагын хамаарал
 Судалгааны дүнгээс үзэхэд БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг сайн хэмээн үнэлэгдсэн 49 оюутны 19 (38.7%)–д хандлага төлөвшсөн, 25 (51.0%)–д хандлага төлөвшиж буй, 5 (10.2%) хандлага төлөвшөөгүй байна. Харин БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг хангалтгүй хэмээн үнэлэгдсэн 608 оюутны 90 (14.8%) хандлага төлөвшсөн, 233 (38.3%) хандлага төлөвшиж буй, 285 (46.8%) хандлага төлөвшөөгүй байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12

Оюутны БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагын түвшин

Мэдлэг Хандлага	Мэдлэгийн оноо (%)				Нийт
	70-89 сайн	50-69 дунд	30-49 муу	30-аас бага хангалтгүй	
Төлөвшсөн	19 (38.7%)	115 (34.6%)	130 (25.4%)	90 (14.8%)	354
Төлөвшиж буй	25 (51.0%)	153 (46.0%)	263 (51.4%)	233 (38.3%)	674
Төлөвшөөгүй	5 (10.2%)	64 (19.2%)	118 (23.0%)	285 (46.8%)	472
Бүгд	49	332	511	608 (40,5%)	1500

Судалгаанд хамрагдагсдын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлагын төлөвшил мэдлэгийн оноотой шууд, дунд зэргийн ($p=0,000$, $r=0,373$) хамааралтай байна.

Хэлэлцүүлэг

БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага нь уг өвчлөлийн тархалтыг бууруулахад чухал ач холбогдолтой тул бид энэхүү судалгаагаар их сургуулийн оюутнуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг хандлагыг үнэлсэн болно.

Судалгаанд хамрагсдын мэдлэгийн дундаж оноо нь авбал зохих нийт онооны гуравны нэг байгаа нь их сургуулийн оюутнуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг хангалтгүй байгааг харуулж байна.

Судлаач Е.Альфрида⁶ (2011) нар Вьетнам улсын ХоШ и Мин⁷ хотын мэргэжлийн сургуулийн

оюутнуудын, Ж.София⁸ (2013) нар Тай⁹ их сургуулийн оюутнуудын БЗДХ-ын мэдлэг, хандлагыг судлан үзэж тэдний мэдлэгийг хангалтгүй байна гэж дүгнэсэн байна. Н. Ариунтуяа, Ч. Байгалмаа (2012) нар Мэргэжлийн Боловсролын Сургалтын Байгууллагад суралцагчдын БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэгийн түвшинг судлан үзэж хангалтгүй байгаа нь тэдний буруу ташаа ойлголттой холбоотой байна. Тухайлбал: Судалгаанд оролцогчид ХДХВ-ын халдвараас сэргийлэх үүднээс сайн дурын шинжилгээ зөвлөгөөнд хамрагдахаас татгалздаг, мөн өөрсдийгөө БЗДХ-т өртөх ямар нэгэн эрсдэлгүй, эрсдэл байгаа эсэх талаар ч тодорхой мэдлэггүй байна гэж дүгнэжээ. Дээрх судлаачдын судалгааны дүнгээс үзэхэд бидний хойч ирээдүй болсон өсвөр үеийнхний БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг хангалтгүй байгаа нь илэрхий байна.

⁶ Alfrida.E

⁷ Ho Chi Minh

⁸ Sofia. G

⁹ Thai

Орчин үед залуучуудын бэлгийн боловсрол түүнийг дагаад мэдлэг, хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотой БЗДХ-аас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох хичээлийг их дээд болон тусгай мэргэжлийн сургуулиудад зааж, бэлгийн боловсролын хөтөлбөрийг бодлоготой хэрэгжүүлэх шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Өсвөр насныханд бэлгийн боловсролын мэдлэгийг хэрэгцээгээр нь бүрэн дүүрэн олговол залуучуудын хандлагад хувьсал гарч түүнийг дагаад нийгмийн хандлага өөрчлөгдөх боломжтой юм.

Ийнхүү БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үнэн зөв мэдлэгийг тодорхой төлөвлөгөөний дагуу дэс дараалалтай олгох нь БЗДХ-ын тархалтыг бууруулах, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн бууруулах онцгой ач холбогдолтой.

Нгуэн¹⁰ (2008) нар Вьетнам улсын Хо Ши Мин хотын Өсвөр насныхны дунд БЗДХ-ууд болон жирэмслэлтээс сэргийлэх мэдлэгийг үнэлсэн судалгааны явцад “Өсвөр насныхны хамгийн сайн мэддэг БЗДХ нь ХДХВ/ДОХ юм” хэмээн тэмдэглэсэн бол бидний судалгаанд хамрагдсан ихэнх оюутнууд 1230 (82,0%) ХДХВ/ДОХ нь БЗДХ-ууд нэг юм гэсэн нь бидний судалгаатай дүйж байна.

Гэвч бусад БЗДХ-ын талаарх мэдлэг маш хангалтгүй байлаа.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын БЗДХ-ууд, халдварлах замууд, урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдлэгийн дундаж оноо 2.26 - 2.53 байхад халдварласан тохиолдолд илрэх шинж тэмдэг, үүсэх хүндрэлийн талаарх мэдлэгийн дундаж оноо 1.94-2.14 байгаа нь энэ талаарх мэдлэг тэдэнд дутмаг байгааг харуулж байна.

Судлаачид (Trajman, 2003, Mwambete, Mtaturu, 2006) оюутнууд БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдээллийн 67%-ийг сургуулиасаа авч байгаа нь хангалтгүй байна гэж дүгнэсэн байхад бидний судалгаанд хамрагдсан оюутнуудын 31 (2,1%) ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлээс, 13 (0,86%) эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэл авдаг байна.

Зарим судлаачид (Alfrida.E нар, 2011) оюутнуудад БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдээллийг сургууль биш сэтгүүл өгч байна, өсвөр насныханд бэлгийн боловсролын мэдлэгийн 96% -ийг ЕБС олгох ёстой хэмээн үзжээ. Бидний болон дээрх судлаачдын судалгааны дүнгээс үзэхэд оюутнуудад энэ тухай мэдээллийг сургуулиуд нь хангалттай өгч чаддаггүй байна.

Монгол улсын нийгмийн үзүүлэлтийн

түүвэр судалгаа (2013)-ны тайлангаас үзэхэд судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн анх бэлгийн хавьталд орсон голч нас 20.4, эрэгтэйчүүдийн хувьд 18.6 байсан байна.

Харин бидний судалгаанд хамрагсдын бэлгийн хавьталд орсон дундаж нас 18.9±1.8 байсан ч, 11 настайдаа 1 охин, 12 настайдаа 1 хүү, 13 настайдаа 3 хүү, 14-15 настайдаа 20, 17 настайдаа 100 оюутан тохиолдлын бэлгийн хавьталд орсон байна. Н.Ариунтуяа, Ч.Байгалмаа (2012) нар МБСБ-д суралцагчдын 39 хувь нь бэлгийн хавьталд орсон ба 97.4 хувь нь 11-18 насандаа, 2.6 хувь нь түүнээс хойш анх удаа бэлгийн хавьталд орсон байна гэж дүгнэжээ.

Дээрх судалгаануудаас үзэхэд бэлгийн хавьталд орсон дундаж нас 18.9 байгаа ч өсвөр насныхан маань бэлгийн зан үйлийн хандлага муу хэн нэгний хүчирхийлэлд 11 наснаас эхлэн өртөж, тохиолдлын бэлгийн хавьталд орсон бололтой.

БЗДХ нь эдгэрэх боломжтой учраас аюултай биш юм гэж судалгаанд хамрагдсан 279 (19,8%) оюутан үзэж байгаа нь тэдэнд хандлага төлөвшөөгүйг, 630 (42%) оюутан энэ талаар мэдэхгүй байгаа нь БЗДХ-уудын ямар нь эдгэрдэг, эдгэрдэггүй талаарх мэдлэг хомс байгааг харуулж байна.

Линн Свенссон¹¹ (2013) нар Тай Их Сургуулийн оюутнуудын БЗДХ-ын мэдлэг, хандлагыг судлан үзэхэд судалгаанд хамрагсдын 36 (24.5%) нь БЗДХ эдгэрэх боломжтой учраас аюултай биш гэж үзжээ.

Хэдийгээр БЗДХ-нь эдгэрэх боломжтой ч шинж тэмдэг илрэхгүй, далд үе гэж байдаг тул халдвартай хэн нэгэнтэй бэлгийн хавьталд хамгаалалтгүй орсон тохиолдолд халдвар дамждаг, халдвар авсан хүн дараагийн хүнийг дахин халдварлуулдаг.

Халдварласан тохиолдолд ирээдүйд үүсэх хүндрэлүүдийн талаарх мэдлэг муутайн улмаас бэлгийн амьдралын идэвхтэй насны залуучуудад хандлага төлөвшөөгүй нь харагдаж байна. Перссон¹², Жарлбро¹³ (1992) нар хэдийгээр өсвөр насныхан бэлгэвч БЗДХ-аас тэднийг хамгаалж чадна гэдгийг мэддэг ч хэрэглээ бага байна гэж дүгнэжээ.

Бидний судалгаанд хамрагдсан оюутнууд ихэнх нь БЗДХ-аас урьдчилан сэргийлэх зорилгоор бэлгэвч хэрэглэх хэрэгтэй гэсэн боловч “Бэлгийн харьцаанд орох нөхцөл бүрдсэн үед бэлгэвч байхгүй” тохиолдолд түүнийг хэрэглэдэггүй болох нь тодорхой байгаа нь дээрх судлаачдын дүгнэлтийг баталж байна.

¹⁰ Nguyen

¹¹ Linn Svensson

¹² Persson

¹³ Jarlbro

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын 40,5%-д нь БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийн түвшин хангалтгүй байв.
2. БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хандлага оюутнуудын 23,6%-д төлөвшсөн, 44.9% төлөвшиж буй, 31.5% хандлага төлөвшөөгүй байна.
3. БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг сайн цөөн оюутнуудын хандлага нь бүрэн төлөвшөөгүй байсан бол мэдлэг нь ч хангалтгүй, хандлага нь ч төлөвшөөгүй оюутнууд дийлэнх хувийг эзэлж байна.

Ашигласан материал

- Ариунтуяа, Н., Байгалмаа, Ч. (2012). МБСБ-ийн суралцагчдын БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлын өнөөгийн байдал. Тайлан. Улаанбаатар
- Хосбаяр, Т. (2011). Тэмбүү өвчний ийлдэс судлалын шинжилгээний чанарыг хангах нь. ЭМЯ, НЭМГ, ЭМШУИС, Глобаль Сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл. Улаанбаатар
- Эрүүл мэндийн яам. (2011). Монгол улсад 2001-2010 онд бүртгэгдсэн бэлгийн замаар дамжих халдварын байдал. ЭМЯ, ХӨСҮТ, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төсөл. Улаанбаатар
- Нэгдсэн Үндэсний Байгууллага. (2014). Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. Улаанбаатар
- Эрүүл мэндийн яам. (2015). Улсын хэмжээнд зонхилон тохиолдох Бэлгийн Замаар Дамжих Халдварын мэдээлэл №19. ЭМЯ, ХӨСҮТ, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төсөл. Улаанбаатар
- ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэ, Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх төслүүдийн тайлан (2003-2013). ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй төсөл. УБ.
- Persson, E & Jarlbro, G. (1992). Sexual behaviour among youth clinic visitors in Sweden: knowledge and experiences in an HIV Perspective. *Genitourin Med.* 68(1).p26-31
- Trajman, A., Belo, M.T., Teixeira, E.G., Dantas, V.C.S., Salomão, F.M. & Cunha, A.J.L.A. (2003). Knowledge about STD/AIDS and sexual behavior among high school students in Rio de Janeiro, Brazil. *Cad. Saúde Pública.* 19(1)
- Alfrida E., Anna S. (2011). Sexually transmitted diseases in Vietnam: Knowledge, attitudes and beliefs among vocational students. Uppsala universitet. Department of Public Health and Caring Science Section of Caring Sciences. <http://ethnomed.org/clinical/communicablediseases/hiv-std-infection>
- Linn Svensson., Sara W., (2013). Knowledge of and attitudes to sexually transmitted diseases among Thai university students. Uppsala universitet. Department of Public Health and Caring Sciences Caring Sciences.
- Mwambete, K.D. & Mtaturu, Z. (2006). Knowledge of sexually transmitted diseases among secondary school students in Dar es Salaam, Tanzania. *African Health Sciences.* p165-169
- Nguyen, Q.H. (2000). HIV/STD infection in vietnamese and Vietnamese americans. *Hämtaden* 1 mars 2011, University of Washington. <http://ethnomed.org/clinical/communicablediseases/hiv-std-infection>
- Sofia G., Annabel S., (2013). Knowledge, attitudes and beliefs about sexually transmitted diseases among Vietnamese students at a vocational school in Ho Chi Minh City. Uppsala universitet. Department of public health and caring sciences. Section of Caring science. <http://ethnomed.org/clinical/communicablediseases/hiv-std-infection>